



БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО: Хүртээмжтэй, хялбар финтек үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх замаар тэдний санхүүгийн хэрэгцээг хангадаг байгууллага байна.

АЛСЫН ХАРАА: Азидаа жишиг болохуйц инновацилаг Финтек болох.

ҮНЭТ ЗҮЙЛ:

1. Ил тод найдвартай байдал- Санхүүгийн бүхий л үйлчилгээг ил тод, хянагдахуйц тайлагнах байдлаар хадгалж харилцагч, хөрөнгө оруулагчид зохицуулагч байгууллагын өмнө хариуцлагатай ажиллана. Харилцагч зээлдэгчийн хувийн мэдээлэлийн чандлан хамгаалж ажиллана.

2. Инноваци технологийн манлайлал- Финтекийн салбарт шинэ шийдлүүдийг санал болгон манлайлж ажиллана.

3. Харилцагч төвтэй үйлчилгээ- Бид санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, уламжлалт банк, санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлэх боломжгүй хувь хүн, бизнест шинэлэг, уян хатан шийдэл санал болгоно. Тэдэнд санхүүгийн боловсрол олгох, эрсдлээ зөв удирдах боломжийг олгох үүднээс тэдэнд шаардлагатай мэдээлэлийг тогтмол өгч ажиллана.

4. Шударга ёс засаглал :Бид ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, компанийн шийдвэр гаргалт, үйл ажиллагааг ёс зүйтэй, шударга, хуулийн хүрээнд явуулна. Аливаа шийдвэр гаргалтад шударга байдлыг хангана.

НМТ-НЫ БОДЛОГО:

Компанийн стратегийн зорилго, зорилтуудыг дэмжсэн, хүртээмжтэй хялбар финтек үйлчилгээг чадварлаг баг хамт олны оролцоотойгоор өөрийн болон харилцагч байгууллагын нөөцийг ашиглан хэрэглэгчдэдээ хүргэнэ. Бид мэдээллийн аюулгүй байдлыг чандлан хамгаалж, Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас гаргасан дүрэм журам, Олон Улсын стандартын шаардлагыг ханган хэрэглэгчийнхээ сэтгэл ханамжид тулгуурласан чанартай үйлчилгээг үзүүлж, тасралтгүй сайжруулалтыг хийж ажиллана.